



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/101

Бсөнбулаг

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 11 дүгээр тогтоол, 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 78 дугаар тогтоол, Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 04 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөр, түүний үр дүнг олон нийтэд тайлагнах сурталчлан таниулах арга хэмжээнд шаардагдах 6,000,000 (зургаан сая) төгрөгийг Боловсролын чанарыг сайжруулах хөтөлбөрийн батлагдсан эх үүсвэрээс гаргаж Аймгийн Боловсрол шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар)-т шилжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

2.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллэхыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав), Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР